




Өөрчлөлт миний гарт

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙМЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЧАДВАР ОЛГОХ
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

СУРАГЧДАД ЗОРИУЛСАН
ГАРЫН АВЛАГА - I



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЧАДВАР ОЛГОХ
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Өөрчлөлт миний гарт

СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА – I

2016 ОН
УЛААНБААТАР ХОТ



Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС) нь эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц, баялаг, мэдлэг, арга ухаан хуримтлуулж, санхүүгийн болон мэдлэг арга зүйн дэмжлэг үзүүлдэг юм.

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилт, МОНЭС-гийн арга зүйн дэмжлэгтэйгээр “ДОРНОД АЙМАГ, БАГАНУУР ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТӨРИЙН ДЭМЖЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” төслийн хүрээнд боловсруулав.

Боловсруулсан: Ч. Ундрах, MHRP
Б. Ариунсанаа, MPH, MSW

Зөвлөсөн: Ч. Алтанцэцэг, Багануур дүүргийн Боловсрол цогцолбор сургуулийн Сургалтын менежер
З. Болормаа, Багануур дүүргийн Гүн Галуутай цогцолбор сургуулийн Сургалтын менежер
Б.Уранжаргал, Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р сургуулийн Сургалтын менежер

Энэхүү гарын авлагыг Монголын эмэгтэйчүүдийн сангийн зөвшөөрөлгүйгээр бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн хэвлэн олшруулахыг хориглоно. Аливаа хэлбэрээр ашиглах тохиолдолд эх сурвалж буюу МОНЭС-ийн нэрийг заавал дурдана.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС)

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Бага тойруу, 48-р байр, 305 тоот


Утас: 77119991

Цахим шуудан: mones@mongol.net | info@mones.org.mn

Нүүр хуудас: [Mongolian Women's Fund](http://MongolianWomen'sFund)

Веб хуудас: www.Mongolianwomensfund

Фэйсбүүк хуудас: [Mongolian Women's Fund](http://MongolianWomen'sFund)



ЗОХИОГЧИЙН ҮГ


Өөрчлөлтийг эхлүүлэх гэж буй эрхэм хүүхдүүд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” хэмээх жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, хандлага төлөвшүүлэх, чадварт сургах 8 модуль бүхий хичээлийн Сурагчдад зориулсан гарын авлагыг хүргэж байгаадаа баяртай байна.

Энэхүү хичээл нь 3-н жилийн туршид үргэлжлэх ба хичээлийн дүнд хүүхдүүд та бүхэн Хүний эрх, Жендэр, Жендэрт Суурилсан Хүчирхийлэл болон түүний үр дагавар, хэрхэн хариу арга хэмжээ авах, хэрхэн яаж өөрийгөө болон ойр дотны хүмүүсээ хамгаалах, цаашлаад хүчирхийллийг хэрхэн таслан зогсоож болох тухай багшийн зааварчилгаа, чиглүүлэгийн дор найзуудтайгаа хамт суралцах болно.

Хичээл нь уламжлалт заах арга зүйгээс арай өөрөөр буюу гол төлөв та бүхний оролцоотойгоор явагдана. Түүнчлэн бие дааж болон багаар ажиллах, тунгаан бодох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, цаашлаад шүүмжлэлт байр сууринаас хандах, дүн шинжилгээ хийх чадваруудыг нэмэгдүүлэх сонирхолтой дасгалуудаас бүрдсэн байгаа. Иймд хичээлдээ идэвхитэй оролцоорой.

Ингээд өөрчлөлтийг гартаа атгацгаая хүүхдүүдээ!



ГАРЧИГ

Модуль 1:	Хүний эрх <i>Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?</i>	08
Модуль 2:	Жендэр <i>Хүйс үү? Жендэр үү?</i>	14
Модуль 3:	Хүчирхийлэл <i>Хүчирхийлэл гэж юу вэ?</i>	22
Модуль 4:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэл <i>Жендэрт Суурилсан Хүчирхийлэл гэж юу вэ?</i>	32
Модуль 5:	Жендэрт Суурилсан Хүчирхийллийн үр дагавар <i>Найздаа туслах боломж надад бий юу?</i>	40
Модуль 6:	Жендэрт суурилсан хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах <i>Би хэнд итгэж болох вэ?</i>	50
Модуль 7:	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Өөрийгөө хамгаалах <i>Миний биеийн хаана хүрч болохгүй вэ?</i>	58
Модуль 8:	Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох <i>Би хүчирхийлэлт бус харилцааг эрхэмлэж чадах уу?</i>	66

Хичээлийн сэдэв:

ХҮН ГЭЖ ХЭН БЭ?

ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Хүн гэж хэн бэ?”, “Эрх гэж юу вэ?”, “Хүний эрх гэж юу вэ?”, “Хүний эрхийг зөрчих гэж юу вэ?” хэмээх хүндхэн асуултуудад хариулж чаддаг болохын тулд хичээлийн зорилго, зорилттой сайтар танилцаарай!

“Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?” сэдэвт хичээлийн гол зорилго нь хөгжөөнт тоглоом тоглож, найзуудтайгаа үзэл бодлоо уралдуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хүний үндсэн эрхүүдийн талаарх анхан шатны, суурь ойлголттой болох явдал юм.

Энэхүү хичээлийг судалснаар сурагчид Та бүхэн,

- Хүний үндсэн эрхийн талаар анхан шатны ойлголттой болно.
- Хүний эрхийн шинж чанарын тухай мэдлэгтэй болно.
- Ялгаварлан гадуурхалт зэрэг хүний эрхийн зөрчлийн талаарх ойлголттой болно.
- Хүний эрхийг дээдлэх хариуцлагыг ухамсарлах юм.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Хүүхдүүд ээ! Дараах дасгалуудыг багшийн өгсөн зааварчилгааны дагуу найзуудтайгаа болон бие даан ажиллах замаар хүний үндсэн эрхийн талаарх суурь ойлголттой болцгооё.

1. Хэлэлцүүлэг
2. Эргэцүүлэл



Дасгал 1

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Багшийн тоглуулсан “Шинэ анги” хэмээх хөгжөөнт тоглоом таалагдсан уу? Хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлэхийн тулд тоглоомын талаар өөрт төрсөн сэтгэгдэл болон мэдрэмжээ дор өгөгдсөн асуултуудын дагуу хариулж бичээрэй!

АСУУЛТУУД

Хүссэн 3 эрхээ авахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?

Шинэ ангийн хүүхдүүдийг 2 багт хуваахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?

А багийн гишүүд Б багийн гишүүдээс давуу эрх мэдэлтэй болоход ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?

Б багийн гишүүд эрх мэдэлгүй болж эхлэхэд ямар санагдсан бэ? Эрхийг нь хэзээ л бол хэзээ хурааж авах аюул дор амьдрах ямар байсан бол? Ямар мэдрэмж төрсөн бэ?

А багийнханд Б багийн гишүүдийн эрхийг авах ямар байсан бэ? Хялбар байсан болов уу? Эсвэл амаргүй байсан болов уу?

Б багийнхан А багийн гишүүдэд эрхээ алдахгүйн тулд ямар ямар арга хэмжээ авч байсан бэ?



Дасгал 2

ЭРГЭЦҮҮЛЭЛ

Энэхүү дасгалыг бие даан ажилласнаар аливаад өөрийн нүдээр дүн шинжилгээ хийх чадвараа нэмэгдүүлэх боломжтой юм. Дараах асуултуудад хариулахдаа тоглоом дээрх ангийн багшийг “нийгэм” хэмээн төсөөлөөрэй!

АСУУЛТУУД

Сурагч бүр бидний эдэлж байсан шиг 3 эрхтэй байх ёстой юу? Хэрэв тийм бол яагаад?

Бидний амьдарч буй нийгэмд хүмүүс өөр өөр бүлгүүдэд хуваагдсан, “ангилагдсан” байдаг уу?” Жишээ нь: хүйсээр, насаар, эрх мэдлээр, албан тушаалаар гэх мэт. Хэрэв тийм бол ямар ямар бүлгүүдийн талаар мэдэх вэ?

Нийгэм нэг бүлэг хүмүүст өөр бүлэг хүмүүсээс илүү эрх мэдэл өгөх нь ямар үр дагавартай гэж бодож байна вэ?

Нийгэм зарим хүмүүст илүү их эрх мэдэл олгох нь шударга уу? Үгүй бол яагаад?

Чиний бодлоор манай нийгэм ихэвчлэн хэнд, ямар бүлэг хүмүүст илүү эрх мэдэл олгодог вэ?

Зарим хүмүүс энэ эрх мэдлээ бусдын эрхийг үл хүндэтгэх, бусдыг дарамтлахад ашигладаг уу? Хэрэв тийм бол хэрхэн?



ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” хэмээх жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг, хандлага, дадал олгох зорилго бүхий 8 модуль хичээлийн хамгийн эхний буюу “Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?” сэдэвт хичээлийг үзэж, өгөгдсөн дасгалуудыг ажилласнаар дараах шинэ мэдлэгийг хуримтлуулсан гэдэгт итгэлтэй байна.

- Бүх хүмүүс эрх тэгш байхаар заяагдсан бөгөөд хүний бүх эрх нэг нь нөгөөгийнхөө дээр, доор гэж байхгүй. Тэгэхээр хүний эрх бол тэгш, шударга, ялгаваргүй, түгээмэл, салшгүй, хуваагдашгүй, харилцан өөр хоорондоо хамааралтай юм.
- Нас, хүйс, гарал угсаа зэргээс үл шалтгаалан хүн бүрт адил тэгш эрх байдаг. Надад байдаг эрх миний найзад ч яг адилхан байдаг. Жишээ нь, дээд ангийн ах надаас насаар ах/эгч учраас намайг дээрэлхэж болно, харин би доод ангийн хүүхдүүдээс ах/эгч учраас тэднийг дарамталж болно гэж бодох нь буруу.
- Аль нэг эрх нөгөөгөөс илүү, эсвэл дутуу биш. Тухайлбал, би сургуульдаа л явж байвал намайг бусад хүмүүс дээрэлхэж, зодсон ч хамаагүй, дүүрсэн хэрэг гэсэн ойлголт байж болохгүй. Өөрөөр хэлбэл, миний сурч боловсрох эрх хангагдаж байвал хүчирхийлэл дарамтаас ангид байх эрх зөрчигдсөн ч хамаагүй гэж ойлгох нь буруу.
- Миний эрх өөр хэн нэгний эрхээс дээгүүр эсхүл доогуур байна гэж байдаггүй. Өөрөөр хэлбэл, А-гийн гэр бүл чинээлэг учраас А магтуулж, сайшаагдана, Б-гийнх дундчуул учраас Б-г үл тоомсорлож болно гэсэн ойлголт буруу бөгөөд энэ нь ялгаварлаж байгаа хэлбэр юм. Хэрэв хэн нэгэн бусдыг ялгаварлаж байвал энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг болно.
- Ялгаварлан гадуурхалт бол хүний эрхийн ноцтой зөрчил юм. Бусдыг насаар нь, хүйсээр нь, ямар айлын хүүхэд гэдгээр нь, ээж аавынх нь эрхэлж буй ажлаар нь, ямар хувцас өмссөнөөр нь, ямар сурдагаар нь ялгаатай харьцаж болохгүй.
- Бусдыг үл хүндэтгэж байна гэдэг бол бусдын эрхийг зөрчиж байна гэсэн үг. Иймд хэн ч миний мөн бусдын эрхийг зөрчих ёсгүй. Өөрөөр хэлбэл би хичээл дээр үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ч бусдын сонсох эрхийг зөрчиж болохгүй. “Өөрийгөө хүндлүүлэхийг хүсвэл бусдыг хүндэл” гэсэн үг бий.
- Хүн бүр адил тэгш эрхтэй байдгийн адил үүрэг хариуцлага гэж байдаг. Тухайлбал, Би бусдын эрхийг зөрчвөл түүнийхээ хариуцлагыг хүлээнэ. Энэ бол миний үүрэг хариуцлага юм.

Хичээлийн сэдэв:

ХҮЙС ҮҮ?

ЖЕНДЭР ҮҮ?



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Хүйс”, “жендэр” гэж чухам юу болох, өөрийнхөө биологийн хүйс болон жендэрийн ялгааг таньж мэддэг болохын тулд дор дурьдсан хичээлийн зорилготой сайтар танилцана уу!

Энэхүү хичээлийн гол зорилго нь “ХҮЙС”, “ЖЕНДЭР” хэмээх нэр томъёоны талаарх мэдлэгээ тэлж, тэдгээрийн хоорондын ялгааг таньж ойлгодог болохоос гадна нийгмээс эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдэд оноосон жендэрийн хэвшмэл дүрийн тухай анхан шатны ойлголттой болно. Улмаар жендэрийн хэвшмэл ойлголтоо дэвшилтэт ойлголт болгон өөрчлөх боломж бий эсэхийг хамтдаа эрэлхийлнэ.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Охид, хөвгүүд ээ! “Хүйс үү? Жендэр үү?” хичээлийн хүрээнд өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бид багшийн тусламжтайгаар хэд хэдэн дасгал ажиллах бөгөөд төсөөлөн бодох чадвараа ашиглах, улмаар түүнийгээ сайжруулах боломжтой болох юм. Дараах дасгалуудыг хамтдаа ажиллацгаая.

1. Хүйсийн үү? Жендэрийн үү?
2. Хүү болох уу? Охин болох уу?
3. Миний бодлоор...
4. Хүйс гэж юу вэ? Жендэр гэж юу вэ? /гэрийн даалгавар/

Дасгал 1

ХҮЙСИЙН ҮҮ? ЖЕНДЭРИЙН УУ?

Дараах өгүүлбэрүүдийн аль нь “хүйсийн” шинжтэй, харин аль нь “жендэрийн” шинжтэй болохыг харгалзах нүдэнд тэмдэглэнэ үү!

Д/д	ӨГҮҮЛБЭР	ХҮЙСИЙН	ЖЕНДЭРИЙН
1.	Охид уян зөөлөн, даруу байдаг.		
2.	Шилжилтийн насанд хөвгүүдийн дуу хоолой нь бүдүүрч, сахал ургаж эхэлдэг.		
3.	Зөвхөн охид л гэр цэвэрлэх, хоол хийх, аяга таваг угаах ажилд анхаарах үүрэгтэй.		
4.	Хөвгүүд, эрэгтэйчүүд БЗДХ-т өртөх эрсдэл өндөр байдаг.		
5.	Эмэгтэй хүн жирэмсэлж, хүүхэд төрүүлдэг.		
6.	Шилжилтийн насны хөвгүүдэд нойтон зүүд үзэгддэг.		
7.	Хөвгүүд гэр бүлээ тэжээх чадвартай, мөнгө сайн олдог эр хүн болж өсөх хэрэгтэй.		
8.	Охидод сарын тэмдэг ирдэг.		
9.	Эр хүн уйлдаггүй.		
10.	Хөвгүүд, эрэгтэйчүүд хүчирхэг, чадалтай. Харин охид, эмэгтэйчүүд сул дорой байдаг.		



Дасгал 2**ХҮҮ БОЛОХ УУ? ОХИН БОЛОХ УУ?**

Хүйс болон жендэрийн талаарх өмнөх дасгалын хүрээнд олж авсан ойлголт мэдлэгээ бататгах зорилгоор “Хүү болох уу? Охин болох уу?” хэмээх сонирхолтой дасгалыг ажиллацгаая. Дараах өгүүлбэрүүдийн талаар хоорондоо ярилцаж, гүйцээж бичээрэй!

ОХИД дараах 2 өгүүлбэрийн талаар ярилцаж, гүйцээж бичээрэй!

Би эмэгтэй хүүхэд болж төрсөндөө баяртай байдаг. Яагаад гэвэл...

Би эрэгтэй хүүхэд байсан ч болоосой гэж боддог. Яагаад гэвэл...

ХӨВГҮҮД дараах 2 өгүүлбэрийн талаар ярилцаж, гүйцээж бичээрэй!

Би эрэгтэй хүүхэд болж төрсөндөө баяртай байдаг. Яагаад гэвэл...

Би эмэгтэй хүүхэд байсан ч болоосой гэж хүсдэг. Яагаад гэвэл...

Гүйцээж бичсэн өгүүлбэрүүдээ ангийнхаа найзууддаа уншиж сонирхуулаарай! Харин найзуудынхаа юу гэж хэлж байгааг доорх зайд товч жагсааж бичээрэй! Гэрийн даалгавараа хийхийн тулд энэхүү тэмдэглэл чинь зайлшгүй шаардлагатай болохыг анхаарна уу!



ТЭМДЭГЛЭЛ



Дасгал 3

МИНИЙ БОДЛООР...

/гэрийн даалгавар/

Энэхүү дасгал ажил нь ангид ажилласан дасгалын үргэлжлэл болохыг анхаарна уу!
Найзуудынхаа хэлсэн өгүүлбэр бүрийг сайтар тэмдэглэж авсан гэдэгт эргэлзэхгүй байна.
Ингээд дээрх жагсаалт бүхий тэмдэглэлээ дахин нэг удаа нягталж хараад аль нь эмэгтэй, аль нь эрэгтэй, харин аль нь хоёр хүйсийн хүнд хоёуланд нь хамааралтай зүйл болохыг ялгаж бичнэ үү!

ЗӨВХӨН ОХИДОД ХАМААРАЛТАЙ

ЗӨВХӨН ХӨВГҮҮДЭД ХАМААРАЛТАЙ

ОХИД, ХӨВГҮҮДЭД АЛЬ АЛИНД НЬ ХАМААРАЛТАЙ

Жагсаалтыг хэрхэн ангилсан талаараа найзуудтайгаа ярилцаж, бусдаас онцгой сонголт хийсэн нэгнээсээ “Яагаад?” гэдгийг асууж чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой.

Зөвхөн охидод эсвэл зөвхөн хөвгүүдэд хамааралтай, хэзээ ч өөрчлөгдөх боломжгүй биологийн хүчин зүйлс гэж байдаг. Жишээ нь, зөвхөн эмэгтэйчүүд жирэмсэлж, хүүхэд төрүүлэх боломжтой бол зөвхөн хөвгүүдийн хоолойн төвөнх нь томорч, дуу хоолой нь бүдүүрдэг гэх мэт. Үүнээс бусад өөрчлөгдөх боломжтой нийгмийн хүчин зүйлсийг охид, хөвгүүд гэх аль нэг биологийн хүйст хамааруулж ойлгох нь өрөөсгөл юм гэдэг дүгнэлтэд хүрэх нь энэхүү дасгалын гол зорилго болно.



Дасгал 4

ХҮЙС ГЭЖ ЮУ ВЭ? ЖЕНДЭР ГЭЖ ЮУ ВЭ?

/гэрийн даалгавар/

Энэ удаагийн хичээлийн хүрээнд хүйс ба жендэрийн талаар юу мэддэг болсон, ямар ойлголт авсан болохоо шалгаж мэдэцгээе. Дараах асуултуудад дэс дараалуулан хариулаарай!

АСУУЛТУУД

Чи ямар хүйстэй вэ?

Чиний ойлгож байгаагаар ХҮЙС гэж юу вэ?

Чиний бодлоор ЖЕНДЭР гэж юу юм бол?

ХҮЙС, ЖЕНДЭР хоёр хоорондоо ялгаатай болов уу? Хэрэв тийм бол ямар ялгаатай гэж чи бодож байна?

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Хүйс үү? Жендэр үү?” хичээлийн хүрээнд дараах үндсэн мэдээллийг өөрийн болгож чадсан гэдэгт итгэлтэй байна.

- Жендэрийн тэгш байдлын үүднээс бол хэн ч инженер болж болно, хэн ч багш эсвэл сувилагч болох боломжтой. Бидний амьдарч буй нийгэм, соёл, орчин нь жендэрийн хэвшсэн ойлголтыг бий болгосон байдаг ба жендэрийн хүйсээс ялгагдах тал нь өөрчлөгдөх боломжтой байдаг. Нийгмээс жендэрийн хэвшмэл дүрүүдийг охид, хөвгүүдэд тулгаж байдаг тул хорио, тээг болох нь олонтаа. Охид гэр цэвэрлэх, харин хөвгүүд гэр цэвэрлэх, хог асгах ёсгүй гэх мэт. Энэ бол нийгмээс эрэгтэй эмэгтэй хүмүүст тулгасан жендэрийн хэвшмэл дүр юм. Энэ ойлголтыг өөрчлөх бүрэн боломжтой.
- Жендэр нь нийгмийн харилцаан дунд хэрэглэгддэг ойлголт тул түүхэн хөгжлийн үед өөрчлөгдсөөр ирсэн. Эрт дээр үед эрэгтэй хүн өрхийг тэжээгч (ан хийх гэх мэт) гэдэг байсан бол орчин үед эрэгтэйчүүд ан хийж, гэр бүлээ тэжээх шаардлагагүй болсон.
- Жендэрийн ойлголтууд дэвшилтэт, хэвшмэл хоёр янз байж болох юм. Дэвшилтэт үзлүүд нь түүхэнд эрх чөлөөгөө эдлэхэд түлхэц, дэмжлэг болсоор ирсэн. Жишээ нь, 20-30 жилийн өмнө бөх, бокс гэх мэт нь зөвхөн эрэгтэйчүүдийн спорт байсан бол өнөөдөр бөх барилддаг, бокс тоглодог хүчирхэг охид, эмэгтэйчүүд олон болсон. Өөрөөр хэлбэл ажил мэргэжилтэй холбоотой жендэрийн ялгаа цөөрсөн гэж үзэж болно. Аливаа ажил мэргэжлийг зөвхөн эмэгтэйчүүдийнх, эсхүл зөвхөн эрэгтэйчүүдийнх гэж хуваах, ангилах, ялгах хандлага үгүй болсоор байна. Жендэрийн ялгаа түүхэн явцад улам цөөрсөөр ирсэн төдийгүй ирээдүйд улам бүр цөөрч, хүйсийг хооронд нь ангилж, ялгасан хандлага үгүй болно.



Хичээлийн сэдэв:

ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүчирхийллийн тухай ойлголт, мэдлэгээ нэмэгдүүлэх хичээл эхлэхэд бэлэн болоод байна. Та бүхнийг хүний эрх болон жендэрийн тухай анхан шатны мэдлэгтэй болсон гэдэгт найдаж байна. Энэ удаагийн хичээлээр бидний эргэн тойронд өдөр тутам яригдаж байгаа хүчирхийлэл гэгч зүйлийн талаар мэдлэгтэй болохын тулд хичээлийн зорилготой танилцана уу.

Энэхүү бүлэг хичээлийн зорилго бол та бүхнийг хүчирхийллийн талаарх үндсэн ойлголттой болгохоос гадна хүчирхийллийн төрлүүд, тэдгээрийн өөр хоорондын ялгааг таниж мэдэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлдэг болгох явдал юм. Өөрөөр хэлбэл сурагчид та бүхнийг

- *Аливаа хүчирхийлэл болон түүний төрлүүдийг тодорхойлж, таньж мэддэг чадвартай болгох,*
- *Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, цаашлаад хүчирхийлэлт харилцаанаас зайлсхийдэг хандлагатай болгоход энэхүү хичээл чиглэх болно.*

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Багшийн өгөх зааварчилгааны дагуу дараах үйл ажиллагаанд идэвхитэй оролцоорой.

- Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх дасгал
- Ойлголтоо нэгтгэх
- Мэдлэгээ бататгах /гэрийн даалгавар/



Дасгал 1

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ДАСГАЛ

Бэлтгэл

Багшийн зааж өгсний дагуу та бүхэн 5 өөр багт хуваагдана. Багийн гишүүд хоорондоо хүчирхийллийн тухай ярилцаж, багшийн тараасан том цаас, фломастерийг ашиглан хүчирхийллийн утгатай зураг зурахад бэлдэнэ.

Дасгал

- Том цаасныхаа оройд “ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж бичээд түүний доод талын зайд хүчирхийллийг илэрхийлсэн аль болох олон төрлийн жижиг жижиг зураг зурна. Зурагт үйл явдал, хүн гээд юу ч зурж болох бөгөөд гагцхүү зурагнаас хүчирхийллийн утгыг харах боломжтой байх ёстой гэдгийг санаарай. Тухайлбал, бусдад дээрэлхүү хандаж байгаа үйл явдал, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хүчирхийлэлд өртсөн эмэгтэй зэрэг юуны ч тухай зурж болох юм шүү.
- Зургаа сайн зурахын тулд бүлэг дотроо хүчирхийлэл гэдэгт чухам ямар үйл явдлыг ойлгох вэ гэдэг талаар сайтар ярилцаарай!
- Зургаа зурж дуусаад баг дундаа зургийн утгыг бусаддаа тайлбарлаж өгөхөд бэлдэнэ. Яагаад зураг дээрх хүүхэд гунигтай байна вэ? Яагаад энэ эмэгтэй уйлж байна вэ гэх мэт зураг дээрх үйл явдлаа асуулт болгон хариулах байдлаар бэлдэнэ.

Мөн түүнчлэн доорх зайнд бие дааж (гэртээ) зураарай!

“ХҮЧИРХИЙЛЭЛ”

Үүний дараа бусад 4 багийн адилаар өөрсдийн зурсан зургаа тайлбарлаарай. Танай багийн ажлыг танилцуулсны дараа багш баг бүрт зориулж тайлбар хийнэ. Ингээд дараагийн үйл ажиллагаанд шилжье.



Дасгал 2

ОЙЛГОЛТ НЭГТГЭХ

Баг бүрийн зурсан зурагт өгсөн багшийн тайлбарт үндэслэн та бүхэн дараах асуултуудад хариулаарай

АСУУЛТУУД

Багш манай багийн зурагт ямар тайлбар хийсэн бэ?

Манай багийн зурсан зураг бусад багийн зурагнаас юугаараа өөр байсан бэ?

Баг бүрийн зургаас харахад хүчирхийлэл гэдгийг юу гэж тодорхойлж болох вэ?

Хүчирхийлэл өөр өөр байдаг уу? Хэрэв тийм бол хэдэн янзын хүчирхийлэл байдаг вэ?

Манай багийн зурагт хүчирхийллийн ямар хэлбэрийг илүү гаргасан бэ?



Дасгал 3

МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ

/гэрийн даалгавар/

Хичээлийн энэ үед та бүхэн хүчирхийллийн тухай тодорхойлолт болон хэдэн янз байдаг талаар мөн яаж илэрдэг тухай тодорхой ойлголттой болсон байгаа. Тэгвэл дараах хүснэгтийг өөрсдийн үгээр бөглөөрэй!

ХҮЧИРХИЙЛЭЛ гэдэг бол _____

Хүчирхийллийн талаарх мэдлэгээ бататгаж, хичээл дээр үзсэн зүйлээ өөрийн болгохын тулд дараах асуултуудад хариулж бичээрэй!

АСУУЛТУУД

Хүчирхийлэл гэж юу вэ? Ямар онцлогтой вэ?

БИЕ МАХБОДИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	
СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ	
БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	
САНХҮҮГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	
ҮЛ ХАЙХРАХ	

Хүчирхийллийн ямар хэлбэрүүд байдаг вэ?

Бие махбодийн хүчирхийллийн онцлог юу вэ?

Сэтгэл санааны хүчирхийллийн онцлог юу вэ?

Санхүүгийн хүчирхийллийн онцлог юу вэ?

Үл хайхрах явдлыг яагаад хүчирхийлэл гэж үздэг вэ?

Чиний бодлоор хүчирхийлэлд хэн илүү өртдөг вэ?





ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” хэмээх жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох зорилго бүхий 8 модуль хичээлийн гуравдугаар хичээл болох “Хүчирхийлэл” сэдвийг судалж, үндсэн мэдлэгтэй болж, буруу ташаа ойлголтоо бусадтайгаа хамтран зөв болгосон гэдэгт итгэлтэй байна.

Мэдлэгээ цэгцлэх үүднээс дараах мэдээллийг уншиж, өөртөө тунгаан бодоорой.

Амжилт хүсье.

- *Хүчирхийлэл гэдгийг маш энгийнээр эрх мэдэлтэй хэн нэгэн өөрийн зорилгоо биелүүлэхийн тулд насаар бага, сул дорой, хүч дутмаг эсвэл эрх мэдэл багатай хэн нэгнийг албадах, тэдэнд хүч хэрэглэж байгаа үйлдлийг ойлгож болно. Тухайлбал, гэр бүлийн хэн нэгэн давуу эрх мэдэлтэй насанд хүрсэн гишүүн (эрэгтэй, эмэгтэй хэн ч байж болно) хүүхдийг өөрийн хүссэнээрээ байлгах, хүссэн зүйлээ хийлгэхийн тулд тэднийг хүсэхгүй байхад нь албадах, улмаар хүч хэрэглэх нь хүүхдийн хүслийн эсрэг үйлдэл буюу хүүхдийн эсрэг хүчирхийлэл болно.*
- *Хэдий тийм ч эрх мэдэлтэй хүн бүр хүчирхийлэгч биш юм. Өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ямар аргыг ашиглаж байна гэдгээс шалтгаалан хүчирхийлэл үйлдэж байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлох боломжтой.*
- *Хүчирхийллийн хэлбэрийг танин мэддэг байх нь түүнээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хэн нэгэнд тусламжийн гарцыг хэлж өгөх ач холбогдолтой. Хүчирхийллийн золиос болсон ихэнх хүмүүс өөрсдийгөө хүчирхийлэлт харилцаа, орчинд байгаагаа хүлээн зөвшөөрөхгүй удаан хугацааг өнгөрөөсөн байдаг. Энэ нь ихэнхдээ тэдний хүчирхийллийг ойлгох ойлголт, танин мэдэх байдал, ялгах чадвар, хэлбэрийн талаар мэдэхгүйтэй холбоотой байдаг.*
- *Хүчирхийллийн хэлбэрийг бие махбодийн, сэтгэл санааны, санхүүгийн, бэлгийн гэх мэтээр ангилах нь түгээмэл байдаг. Заримдаа бие махбодийн хүчирхийлэлд бэлгийн хүчирхийллийг оруулах нь ч бий. Мөн хохирогч нь хэн байна гэдгээс шалтгаалж хүчирхийллийг хүүхдийн эсрэг, эмэгтэйчүүдийн эсрэг, ахмадын эсрэг хүчирхийлэл гэж нэрлэдэг.*

- *Түүнчлэн үл хайхрах явдлыг хүчирхийллийн хэлбэрт тооцож ойлгодог. Энэ нь илүүтэй хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ахмадын эсрэг хүчирхийлэлтэй холбоотой яригддаг бөгөөд хүн бусдаар хайрлуулах ёстой харин энэхүү хайрлуулах эрхийг эдлүүлэх үүргийг хуулийн өмнө тухайн хүүхдийн эцэг эх эсвэл тухайн настны үр хүүхдүүд хүлээсэн байдаг. Тэгэхээр хүний эдлэх ёстой хайр, халамжийг эдлүүлэхгүй байх нь хүчирхийлж буй явдал гэж ойлгодог байна.*

Хичээлийн сэдэв:

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Бид өмнөх хичээлээр хүчирхийлэл гэж юу болох, хэдэн төрөл байдаг мөн яаж илэрдэг талаар бүтээлчээр сэтгэн хамтдаа сурцгаасан бол энэ удаад жендэрт суурилсан хүчирхийллийн талаар үзэх гэж байна. Та бүхэн хичээлийн зорилгод анхаарлаа хандуулаарай.

Энэхүү хичээлийн зорилго нь өмнө үзсэн жендэр болон хүчирхийлэл сэдэвт хичээлээр олж авсан мэдлэгт тулгуурлан жендэрт суурилсан хүчирхийллийн ялгаатай байдал, онцлогийг танин мэдэхэд оршино.

Ингэснээр та бүхэн

- Жендэрт суурилсан хүчирхийллийн тодорхойлолтыг ухаж ойлгох
- Хүчирхийлэл болон жендэрийн холбоо хамаарлыг таних
- Хүчирхийлэл нь зөвхөн хүйс хооронд үйлдэгддэг гэмт хэрэг биш гэдгийг ойлгох чадвартай болно.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дарааллын дагуу багшийн зааварчилгааны дор найзуудтайгаа болон бие дааж ажиллана.

- Жендэрийн хайрцаг
- Бодит жишээн дээр ярилцах
- Бие даан суралцах

Дасгал 1

ЖЕНДЭРИЙН ХАЙРЦАГ

Бэлтгэл

Багшийн хэлсний дагуу та бүхэн охид, хөвгүүдээрээ ялгаран танхимын 2 хэсэгт хуваагдан суугаарай. Мөн багтаа флипчарт цаас болон маркер авч ирэн, бэлтгэлээ хангахаа мартуузай.

Даалгавар

Хэрвээ чи хөвгүүдийн багт орсон бол танай баг эрэгтэй хүүхэд, харин охидын багт орсон бол эмэгтэй хүүхэд зурах даалгаврыг багш өгнө. Танай баг өөрсдийн зурсан хүүхэддээ нэр өгнө шүү. Ингээд нийгэм, олон нийт, хүрээлэн буй хүмүүс, гэр бүлийнхэн, найзууд нь тухайн хүүхдийг ямар байгаасай гэж хүсдэг болохыг хоорондоо яриад, ярьсан зүйлээ зургаа тойруулаад бичээрэй. Жишээ нь: охид бол эелдэг даруу, дөлгөөн, гэрийн ажилд сайн, онц сурдаг байвал гоё бол хөвгүүдийг хүчтэй, зоригтой, шийдэмгий гэх мэтээр та нарын ярианаас ямар санаа гарна түүнийгээ зургаа тойруулан доорх зайнд бичээрэй.

Зурагаа танилцуулах

Хэрэв танай баг зурагаа зурж дууссан бол өөрсдийн зурагаа нөгөө багтаа танилцуулаарай. Ингэж танилцуулахын сацуу дараах асуултуудад хариулт бэлдээрэй.

Та бүхний зургийг өөрөөр тайлбарлаж болох уу? Жишээлбэл...?

Хэрэв тийм бол хүмүүс үүнд хэрхэн хандах бол? Жишээлбэл...?

Та нарт тохиолдсон бодит жишээ байна уу? Бусадтайгаа хуваалцана уу!

Дасгалыг дүгнэх

Хүүхдүүдээ та бүхний зурсан зураг бол бидний амьдарч буй нийгмийн, бусдын зүгээс охид, хөвгүүд та бүхнийг ямар байгаасай гэж хүсдэг талаарх бодол буюу “жендэрийн хайрцаг” юм. Өөрөөр хэлбэл нийгэм хүмүүсийг тэдний биологийн хүйсээс нь хамаарч ямар байлгахыг хүсч байгаа нь “жендэрийн хайрцаг” хэмээн ойлгогдоно. Тухайлбал, охидыг онц сурдаг, даруу төлөв зантай, хөвгүүдийг зоригтой, баатарлаг, хүч чадалтай байх шаардлагатай мэтээр хандах нийгмийн хандлага нь охид, хөвгүүдийг өөрөөрөө байх боломжгүй болгож “хайрцаглаж” байдаг. Нийгмээс өгсөн энэхүү хүлээлт, шаардлагад нийцэхгүй өөрөөр хэлбэл “хайрцаг”-аас гадна байх тохиолдолд олон сөрөг үр дагавар учирдаг бөгөөд тэдгээрийн нэгд “жендэрт суурилсан хүчирхийлэл” ордог. Манай улсын хуулинд ЖСХ-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хуулийн тодорхойлолт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

4.1.8 “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Тодорхойлолтоос харахад жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэгт хэн нэгнийг эмэгтэй эсвэл эрэгтэй болж төрснийх нь төлөө бие мабодь, сэтгэл санаа, эд материалын хор хохирол учруулах бүх үйлдлийг ойлгож болохоор байна. Тэгэхээр эмэгтэй л хүн бол заавал гэр цэвэрлэх ёстой, эрэгтэй л хүн бол заавал хүчний ажил хийх ёстой гэж бодож бусдад тулгах нь орчин үед зохимжгүй үйлдэлд ордог болжээ.



Дасгал 2

БОДИТ ЖИШЭЭН ДЭЭР АЖИЛЛАХ

Хүүхдүүдээ та бүхэн одоогоор жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх товч ойлголттой болсон гэж найдаж байна. Тэгвэл энэхүү дасгалаар ойлголтоо бататгаж, илүү ойлгохын тулд дараах амьдрал дээр болсон 3 явдалтай танилцаарай. Тэгээд өгөгдсөн асуултад хариулахын тулд багаараа ярилцаарай.

Хэрэв бүх жишээн дээр ажиллаж амжихгүй бол гэртээ дахин хийж болно шүү.

Бодит жишээ 1

Ц 15 настай, эрэгтэй. Тэрээр багадаа маш хүндээр өвдөж байсан учраас сургуулиасаа чөлөө авч, удаан хугацаанд гэртээ байсан. Саяхнаас хичээлдээ явж эхэлсэн. Тэр бусад хөвгүүдээс намхан, туранхай, жижиг биетэй. Биеийн эрүүл мэндийн байдлаасаа шалтгаалаад спортоор хичээллэх боломжгүй бөгөөд биеийн тамирын хичээлээс чөлөөлөгдсөн. Ангийнхан нь түүнийг “сульдаа”, “тэнэг”, “ижил хүйстэн шиг”, “охин шиг” гэх мэтээр шоолж, гоочилдог. Мөн ангийн хөвгүүд нь байнга мөнгө нэхэж дарамталдаг төдийгүй өгөхгүй бол зоддог.

Бодит жишээ 2

Н 16 настай, эмэгтэй. Үеийнхээ охидоос илүү биерхүү, бүдүүн хоолойтой, чөлөөт бөхөөр хичээллэдэг. Энэ спортдоо маш их дуртай бөгөөд амжилттай сайн тамирчин. Ихэнх цагаа спорт танхимд бэлтгэл хийж өнгөрөөдөг. Түүнийг ангийнхан болон багш нар нь эмэгтэй байхыг шаарддаг бөгөөд үеийн охид нь түүнтэй найзлахаас татгалздаг. Учир нь түүний байгаа байдал яг л эрэгтэй хүүхэд шиг, охидын сонирхдог зүйлсийг нэгийг нь ч сонирхдоггүй гэдэг.

Бодит жишээ 3

Манай ах намайг байнга зоддог. Урьд нь манай аав архи уудаг байхдаа ээж, ах, бид нарыг дандаа зоддог байсан. Харин 2 жилийн өмнөөс архи уухаа болиод бид нарыг зодохоо ч бас больсон. Гэтэл ах намайг зоддог болж эхэлсэн. Гэр цэвэрлэсэнгүй, хичээлээ хийсэнгүй, эрэгтэй хүүхэдтэй уулзлаа гээд шалтаг л гарвал миний толгой руу цохиж, гэдэс рүү өшиглөдөг...

АСУУЛТУУД

Танай багт өгөгдсөн жишээ ЖСХ мөн үү, тийм бол яагаад үгүй бол яагаад?

Энэ тохиолдолд хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нь хэн байсан бэ?

Хохирогч нийгмээс оноосон дүрээс өөр байсан уу?

Хүчирхийлэлд өртөх болсон шалтгаан юу байв?



Дасгал 3

БИЕ ДААН СУРАЛЦАХ

/гэрийн даалгавар/

Та бүхэн ангидаа жендэрт суурилсан хүчирхийллийн талаар үзэж, бодит жишээн дээр задлан шинжлэл хийсэн билээ. Одоо харин танай анги хамт олон, та нарын явдаг дугуйлан, клуб зэрэгт болдог бүхий л үйл ажиллагааны тухай эргэцүүлэн бодоод, дараах бодомжуудад ганцаараа хариулт өгч, бичээрэй.

Хүний бие махбодид учирсан гэмтэл бэртлийг л жендэрт суурилсан хүчирхийлэл гэнэ.

Тийм, яагаад гэвэл

Үгүй, яагад гэвэл

Зөвхөн охид, эмэгтэйчүүд л жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болдог.

Тийм, яагаад гэвэл

Үгүй, яагаад гэвэл

Охид, хөвгүүд хүсэл сонирхол, мөрөөдлөө биелүүлэх нь нийгмийн хүлээлттэй давхцахгүй байж болно.

Тийм, яагаад гэвэл

Үгүй, яагаад гэвэл

Эмэгтэй хүн айл гэрийн эзэгтэй, ирээдүйн ээж болох тул багаасаа л энэ үүрэгт бэлтгэгдэх ёстой.

Тийм, яагаад гэвэл

Үгүй, яагаад гэвэл

Эрэгтэй хүн эмэгтэй хүнээс ухаантай тул айл гэрийг тэжээх, авч явах үүргийг хүлээнэ.

Тийм, яагаад гэвэл

Үгүй, яагаад гэвэл

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Нийгмээс өгсөн дүр, хэвшмэл хандлагаас өөр эсвэл өвөрмөц байдлаас үүдэн бусдыг доромжлох, нэр хоч өгөх, хүч хэрэглэх нь ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ юм.

Мөн эмэгтэй эсвэл эрэгтэй болж төрсөнөөсөө шалтгаалан хүний эрхийн зөрчилд өртөж байна. Жишээлбэл “сайн эхнэрийг сард нэг удаа зод” гэх мэтчилэн эр нөхөр бол эхнэрээ зодох ёстой гэсэн буруу ойлголт, хандлага болоод хүчирхийлэл үйлдэгчдийг үүсгэж байна. Ганцхан эрэгтэй хүн эрх мэдлийн давуу байдал, хүч чадлаа ашиглан эмэгтэй хүнийг хүчирхийлэх биш, хүйс дотроо буюу эмэгтэй хүмүүс, эрэгтэй хүмүүс хоорондоо бие биенээ хүчирхийлэх, доромжлох гэх мэт маш өргөн ойлголттой.

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч нь зөвхөн охид, эмэгтэйчүүд биш юм. Нийгмийн хүлээлттэй үл нийцсэн хөвгүүд, эрэгтэйчүүд ч ЖСХ-ийн хохирогч болдог. Тухайлбал, дэлхийн олон улс оронд өсвөр насны эрэгтэй хүүхдүүд хүчирхийллийн золиос буюу хэрэг төвөгт орооцолдох, гэмт бүлэглэлийн гишүүн болох, уруу татагдах элбэг байдаг бөгөөд энэ нь эр хүн гэдгээ үеийнхэндээ харуулах, батлах гэсэн сэдлээс үүдэлтэй байдгийг тогтоожээ.

Хичээлийн сэдэв:

НАЙЗДАА ТУСЛАХ БОЛОМЖ
НАДАД БИЙ ЮУ?



МОНДУУЛЬ 5

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛИЙН ҮР ДАГАВАР

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүүхдүүдээ өмнөх хичээлээр та бүхэн жендэрт суурилсан хүчирхийлэл гэж чухам юу болох, бидний өдөр тутмын амьдралд яаж илэрдэг, юунаас болдог болохыг үзсэн билээ. Харин энэ удаагийн хичээлээр ЖСХ-ийн үр дагавар тэр дундаа бие махбодид ямар үр дагавар учирдаг талаар үзэж судална. Ингэхдээ бид дүрийн тоглолт хийж сонирхолтой байдлаар хичээлээ явуулах тул идэвхитэй оролцоорой.

Хичээлийн зорилтууд

- *ЖСХ-ийн бие махбодид учирч болох үр дагаврын талаар анхан шатны ойлголттой болох*
- *Та нарын найз нөхөд, ойр дотны хүмүүс хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй гэмтэл авсан тохиолдолд тусламж эрэх зан үйлтэй болох*

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Хүүхдүүдээ хичээлийн дараалалтай танилцаж хичээлийн бэлтгэлийг хангаарай.

1. Дүрийн тоглолт
2. Бүлгийн ажил



Дасгал 1

ДҮРИЙН ТОГЛОЛТ

Багшийн тусламжтайгаар нэг багт 5 сурагч байхаар тооцож багт хуваагдаарай. Танай багт ирсэн жишээг сайтар уншин жүжигчилсэн тоглолтод бэлдээрэй. Хэн ямар дүрд хэрхэн тоглохыг баг дотроо сайтар ярилцаарай. Жүжигчилсэн тоглолт 3-5 минутад багтах шаардлагатайг анхаараарай!

Өгөгдөл 1

Ц, З, М гурав ангийнхаа 3 хөвгүүний хамт хичээлийн дараа анги цэвэрлэхээр хуваарилагджээ. Ангийн багш нь охид, хөвгүүд гэлгүйгээр цэвэрлэгээний бүх ажлуудыг тэнцүү хувааж хийхийг шаардаад өөр ангид хичээл заахаар явжээ. Ангийн багш байхгүйг далимдуулан хөвгүүд үүрэгт ажлаа хийлгүйгээр ангид хөзөр тоглож эхэлсэн байна. М тэднийг цэвэрлэгээгээ хийхийг шаардтал, “охид л цэвэрлэгээ хийх ёстой биздээ?” гээд огт анхаарал хандуулаагүй байна. Гэтэл Ц “Та нарыг цэвэрлэгээгээ хийхгүй байна гэж багшид очиж хэллээ шүү!” гэтэл ангийнх нь нэгхөвгүүн “Сүртэй юм бэ чи! Хийх ёстой ажлаа хийж чадахгүй юундаа хов зөөх гээд байгаа юм бэ?” гээд гартаа тааралдсан нэг зүйлийг шидтэл Ц-ийн духанд онож, толгойг нь хагалжээ. Ц эмнэлгийн тусламж авах шаардлагатай болсон байна.

Өгөгдөл 2

А бол сургуулийнхаа хамгийн царайлаг бас гоё биетэй, даруухан охин юм. Сургуулийн бүх л хөвгүүд түүнийг шохоорхоно. Гэвч А зөвхөн хичээлдээ л анхаарч энэ бүгдийг тоодоггүй байв. Харин дээд ангийн охид А-д тийм ч тааламжтай биш ханддагаас гадна сургуулийн коридорт зөрөхдөө мөрлөх, дэгээдэх, үг хэлээр доромжлох зэргээр ханддаг байлаа. Нэг өдөр сургуулийн коридорт энэ үйлдэл давтагдаж, А-г явж байхад нь дэгээдэж унагаасан бөгөөд тэрээр унаснаасаа болоод өвдгөө гэмтээсэн. А үүнээс болж хэд хоног хичээлдээ явах боломжгүй болсноос гадна хичээлдээ муудаж, дуугүй зожиг болж өөрчлөгдөж эхэлжээ. Найзыгаа өөрчлөгдөж байгааг сайн найз Ц хараад түүнд урмын үг хэлж тайвшруулахыг хичээсэн ч үр дүнгүй байв. Эцэст нь энэ талаар сургуулийнхаа нийгмийн ажилтанд хэлсэн нь зөв алхам болж чадсан юм.

Өгөгдөл 3

С-ийн хувьд 3 бол энэ сургуульд шилжиж ирээд найзалж байгаа хамгийн сайн найз нь юм. Амралтын 2 өдөр дуусч хичээлдээ ирэхэд 3-ийн бугуй хөхөрсөн байхыг С хараад яасныг асуухад гэрээсээ гарахдаа унаж ийм болгосон хэмээн хариулжээ. Энэ явдлаас нэлээд хэд хоногийн дараа 3-ийн гар дахиад л хөхөрсөн байв. Үүнийг С хараад яагаад ийм болсныг асуухад 3 урьдын адил хариуллаа. Гэвч үүнд С итгэсэнгүй дахин дахин асуухад 3-ийн аав хүнтэй суусан бөгөөд хойд ээж нь түүнийг гэрийн ажил хийсэнгүй хэмээн зоддог байсныг уйлан уйлан ярьжээ. С найзыгаа тайвшруулж аргадаад энэ хэргийг дуугүй өнгөрч болохгүй гээд түүнд тусалж чадах хүнд хэлэхээр ярилцаж тогтлоо. Маргааш нь 2 найз хичээл тарсны дараа ангийн багшдаа болсон явдлыг яриу. Ингэснээр ангийн багш сургуулийн нийгмийн ажилтан нар хороо, цагдаа гээд хөл хүрэх газраараа явж энэ хэргийг эерэгээр шийдэж чадсан юм.

Өгөгдөл 4

Б9-р ангиа сумандаа төгсөж 10-р ангиасаа эхлэн аймгийн төвд суралцахаар болов. Учир нь суманд 9 жилээс дээш анги байдаггүй байв. Б-ын гэр бүлийнхэн аймагт таних хүнгүй учир дотуур байранд байхаар боллоо. 9 сарын 1-ээс эхлэн Б-д болон бусад хөдөөнөөс ирсэн хөвгүүдэд нэг хэцүү асуудал гарсан нь дээд ангийн хөвгүүд тэднийг дээрэлхэх, юмыг нь булаан авах заримдаа зодох тохиолдол байдаг байв. Энэ бүгдийг ангийн охид мэдээж мэддэг байснаас гадна байдаг л зүйл гэж ойлгодог байсан юм. Гэхдээ энэ нь Б-д маш хүндээр тусч түүний сурлага муудаж, ойр ойрхон хичээлээ таслан хөдөө байдаг гэрлүүгээ явдаг болов. Б-той нэг ширээнд суудаг охин түүнд хэцүү байгааг ойлгосон учраас энэ бүгдийг Б-ын ар гэрийнхэнд хэлснээр эцэг эх нь сургуулийн захиргаанд гомдол гаргасан байна. Ингэснээр сургуулийн захиргаа энэ асуудалд арга хэмжээ авч дахин ийм явдал гарсангүй.





Дасгал 2

БҮЛГИЙН АЖИЛ

Жүжигчилсэн тоглолтоо үзүүлж дууссаны дараа дахин бүлэгт хуваагдана. Багшийн зүгээс тавих доорх асуултуудад хариулахад бэлдээрэй. Тэдгээр асуулт нь заавал танай багийн тоглолттой холбоотой биш тул бусад багийн тоглолт бүрт ямар агуулгатай байсныг эргэн санаарай. Ингэснээр багууд өөрсдийн үзүүлсэн түүхийн тухай биш өөр багийн үзүүлсэн түүхийн талаар ярилцах юм. Доорх асуултуудын дагуу хэлэлцүүлгээ өрнүүлнэ.

ӨГӨГДӨЛ 1-ИЙН АСУУЛТУУД

Охид, хөвгүүдэд хандах ангийн багшийн хандлага ямар байсан бэ?

М, Ц 2 ямар арга хэмжээ авсан бэ?

Ц-д ямар гэмтэл учирсан бэ?

Зөвхөн охид л цэвэрлэгээний ажил хийх ёстой гэсэн хандлага нь жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү? Хэрэв тийм бол яагаад? Үгүй бол яагаад?

Олон нийтийн энэхүү хандлагаас үүдээд охидод ямар нэгэн сөрөг үр дагавар учирч болох уу?

ӨГӨГДӨЛ 2-ЫН АСУУЛТУУД

А-д юу тохиолдсон бэ?

А-д тохиолдож байгаа зүйл жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү?

Уг явдлаас болоод А хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Сургууль дээрх таагүй зүйлсийг эцэг эхтэйгээ ярилцах хэрэгтэй юу?

Ц найзынхаа төлөө ямар үйлдэл хийсэн бэ?



ӨГӨГДӨЛ 3-ЫН АСУУЛТУУД

3 өөрт тохиолдсон явдлаа хэн нэгэнд хэлсэн үү?

3 яагаад найздаа худлаа хэлсэн гэж бодож байна вэ?

3-д тохиолдсон явдал жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү?

С найздаа тохиолдсон явдлыг ангийн багшдаа хэлсэн нь зөв үйлдэл болсон уу?

С-ийн хийсэн үйлдэл нь ямар үр дүн авч ирсэн бэ?

ӨГӨГДӨЛ 4-ИЙН АСУУЛТУУД

Б-д тохиолдож байгаа зүйл энгийн, байдаг л зүйл мөн үү?

Б өөрт нь тохиолдож байгаа зүйлийн талаар хэн нэгэнд хэлэх ёстой байсан уу?

Б-д тохиолдож буй зүйл жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү?

Б-ын ширээний найз болсон явдлын талаар түүний гэр бүлийнхэнд хэлсэн нь зөв үйлдэл байсан уу?

Хэрвээ энэ үйлдэл зөв байсан бол ямар үр дүн авч ирсэн бэ?





ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү хичээлээс дараах дүгнэлтийг хийж болно.

- ЖСХ-ийн улмаас үүсэх үр дагавар янз бүр байдаг.
- ЖСХ нь хүний биед үл мэдэгдэм гэмтэл учруулж болох хэдий ч хүний сэтгэл санаа, өөртөө итгэх итгэл, эрхэм чанар, биеэ авч явах байдалд сөрөг үр дагавар авч ирдэг.
- Хэн ч хүчирхийлэлд өртөхийг хүсдэггүй. Хүчирхийлэл нь хүний нэр төр, эрхэм чанартай салшгүй холбоотой байдаг учраас хүчирхийлэлд өртсөн хүмүүс өөрсдийгөө тэр бүр илчилдэггүй. Иймд ойр дотны хэн нэгэн хүн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртсөн байж болзошгүй гэмтэл биедээ авсан тохиолдолд анзаараагүй мэт өнгөрч болохгүй. Тэр тусмаа бага насны хүүхдэд заавал туслах ёстой бөгөөд энэ нь иргэн бүрийн үүрэг гэдгийг ухамсарлах ёстой. Гадаад улс оронд бага насны хүүхдэд туслаагүйгээс насанд хүрсэн хүмүүст хүлээлгэх хариуцлагыг нарийн заасан байдаг.
- Хүчирхийллийн хажуугаар дуугүй өнгөрч болохгүй. Хэрэв өөрөө туслах боломжгүй гэж үзэж байгаа үед энэ асуудлыг шийдэж чадах хэн нэгэн насанд хүрсэн хүнд мэдээлэх хэрэгтэй.
- ЖСХ-ийн улмаас сэтгэл санаанд хохирол учрахаас гадна биеийн эрүүл мэнд, цаашлаад амь насанд ч аюултай үр дагаварыг авчирч байдаг.
- ЖСХ-ийн улмаас бие махбодид учрах хохирол нь хүний нүдэнд ил харагдахуйц байдаг ч гэлээ түүний уршгаар хүний сэтгэл санаа, сэтгэл зүйд асар их хохирол учруулдаг. Харин тэр нь бусдад ил харагдахгүй байх талтай байдаг тул хүмүүс төдийлөн ач холбогдол өгөхгүй байх хандлагатай байдаг.

Хичээлийн сэдэв:

БИ ХЭНД ИТГЭЖ
БОЛОХ ВЭ?



МОНДУУБ 6

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛД, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Бидний дийлэнх нь ойр дотны хүмүүстээ ихээхэн итгэл хүлээлгэсэн байдаг. Аавдаа, ээждээ, эмээдээ, өвөөдөө, ахдаа, эгчдээ итгэдэггүй хүн гэж тун ховор. Тэгвэл бидний эргэн тойронд зөвхөн гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсээс гадна олон олон итгэл хүлээлгэж болох насанд хүрсэн хүмүүс байдаг. Аавдаа, ээждээ хэлэхээс эмээдэг зүйлээ дотны гэж боддог, итгэдэг хэн нэгэндээ дэлгэх тохиодол бидний амьдралд бий. Тэгвэл итгэл хүлээлгэсэн хэн нэгнээ олохын өмнө хийчээлийнхээ зорилготой танилцана уу!

“Би хэнд итгэж болох вэ?” хичээлийн гол зорилго нь өөрийн хамгийн их итгэл хүлээлгэсэн насанд хүрсэн хүн хэн байж болохыг тодорхойлж сурахаас гадна жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хамгийн анх мэдээлж болох насанд хүрсэн хүмүүсийн нэрсийн жагсаалттай болно.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дасгалуудыг багшийн удирдлага дор найзуудтайгаа болон бие даан ажиллах замаар итгэл хүлээлгэж болох насанд хүрсэн хүмүүс чинь хэн бэ гэдгийг олж мэдэцгээе!

1. “Н” охинд юу тохиолдсон бэ?
2. Миний итгэдэг хүмүүс бол..
3. “Миний итгэдэг хүн” эргэцүүлэл



Дасгал 1

"Н" ОХИНД ЮУ ТОХИОЛДСОН БЭ?

"Н" охинд тохиолдсон явдлыг анхааралтай уншиж, дотроо ямар нэг зүйлийг эргэцүүлсэн гэдэгт итгэлтэй байна. Дараах асуултуудын дагуу найзуудтайгаа чөлөөтэй ярилцана уу. Мөн түүнчлэн өөрийн бодлоо товч тэмдэглэж үлдээгээрэй!

"Н" ОХИНД ТОХИОЛДСОН ЯВДАЛ

"Н" бол доороо 3 дүүтэй айлын том охин. Аав нь хүнд өвчний улмаас хэдэн жилийн өмнө бурхан болсноос хойш тэдний амьдрал хүндхэн болж эхэлжээ. Ээж нь нэгэн улсын эмнэлэгт сувилагч хийдэг тул ихэнхдээ ээлжинд гарч эзгүй байдаг. Заримдаа илүү цагаар ажиллаж, гэртээ ирэхгүй 2-3 хоног болох тохиолдол ч байдаг байна. Ээжийнхээ эзгүйд "Н" охин л гэрийнхээ бүх ажлыг зохицуулдаг. Дүү нараа харах, сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах, гэрээ цэвэрлэх, хоолоо хийх, хувцасаа угаах, түлээ нүүрсээ бэлтгэх гээд "Н" охинд хийх ажил маш их байдаг.

Ээж нь хүүхдүүдээ эзгүй, харах хүнгүй орхидогтоо байнга санаа нь зовдог байсан тул хүүхдүүдэд нь ханьтай гээд хашаандаа айл буулгахаар болжээ. Хөдөөнөөс хотод орж ирээд удаагүй байгаа тохьтой, томоотой гэмээр 30 орчим насны нэг залуу, түүний дүү нь гэх 1-р курсын оюутан охин хоёрыг хашаандаа буулгажээ. Ажилдаа явсан эзгүй хойгуур нь хүүхдүүдийг нь анхаарч, орж гарч байгаарай гэж ээж нь байнга тэдэнд захидаг байв.

Гэтэл нэг өдөр "Н" охиныг гэртээ байхад хөрш залуу "Хүйтэн цай байна уу? Ахдаа аяга сайхан хүйтэн цай өгөөч. Ам цангаж үхлээ" гэсээр орж иржээ. Энэ үед дүү нар нь цэцэрлэг, сургуульдаа явсан байж. "Н" охиныг цай хийж өгөх зуур хөрш залуу түүнийг араас нь тэвэрч, хүзүү хацар гэх мэт газар нь хүчээр үнсэхийг оролдсон байна. Энэ явдал "Н" охинд маш хүнд туссан.

АСУУЛТУУД

“Н” охинд юу тохиолдсон бэ?

Чиний бодлоор “Н” охин одоо яах ёстой вэ? ...?

“Н” охин өөрт тохиолдсон зүйлийн талаар хэн нэгэнд хэлэх хэрэгтэй юу? Хэрэв тийм бол хэнд хэлэх вэ? Хэлэх хэрэггүй бол яагаад?

Хэн нэгэнд хэлэх нь ямар ач холбогдолтой бол?

Өөрт тохиолдсон зүйлийн талаар хэн нэгэнд хэлэхгүй байх нь ямар үр дагавартай гэж чи бодож байна?





Дасгал 2

МИНИЙ ИТГЭДЭГ ХҮМҮҮС БОЛ...

Дараах хэдэн асуултанд хариулах замаар хамгийн итгэж болох “насанд хүрсэн” хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргана уу. 1 асуултын ард 1-2 хүний нэрийг бичих боломжтойг анхаараарай. Асуулт бүрийг анхааралтай уншиж, чин сэтгэлээсээ хариулахыг хүсье!

АСУУЛТУУД	МИНИЙ ИТГЭДЭГ ХҮМҮҮС
Ямар нэгэн бэрхшээл тулгарахад туслалцаа үзүүлж чадах “насанд хүрсэн” хүнийг хэн гэж бодож байна вэ?	
Ямар нэгэн бэрхшээл, шийдэж чадахааргүй асуудал тулгарахад илэн далангүй ярилцаж болох “насанд хүрсэн” хүнийг хэн гэж бодож байна вэ?	
Чиний хувьд Хажууд нь байхад аз жаргал, амар тайван байдлыг мэдрүүлдэг “насанд хүрсэн” хүн хэн бэ?	
Өөрийг чинь маш сайн сонсож чаддаг “насанд хүрсэн” хүн хэн байж болох вэ?	
Өмнө нь чамд чин сэтгэлээсээ туслалцаа үзүүлж байсан “насанд хүрсэн” хүн хэн бэ?	
Чамайг маш сайн ойлгодог “насанд хүрсэн” хүн хэн бэ?	

Асуултуудад хариулахад ямар байсан бэ? Хэцүү байв уу? Аль эсвэл хялбар байв уу? Одоо нэрсийн жагсаалтаа дахин нэг удаа сайтар нягталж хараад хамгийн ихээр итгэл, найдвар хүлээлгэж болох, нууцыг чинь хэзээ ч хэнд ч задруулахгүй, чамд ямар нэгэн бэрхшээл тулгарахад чин сэтгэлээсээ тусалж чадах 3 хүнийг сонгоод, доорх хүснэгтэд нэрсийг нь, мөн

түүнчлэн яагаад тэдгээр хүмүүсийг хамгийн их итгэж болох хүнээр сонгосон шалтгаанаа бичээрэй!

Д/д	Итгэж болох хүмүүсийн нэрс	Яагаад хамгийн их итгэж болох вэ?
1.	Өөрийг чинь маш сайн сонсож чаддаг “насанд хүрсэн” хүн хэн байж болох вэ?	
2.	Өмнө нь чамд чин сэтгэлээсээ туслалцаа үзүүлж байсан “насанд хүрсэн” хүн хэн бэ?	
3.	Чамайг маш сайн ойлгодог “насанд хүрсэн” хүн хэн бэ?	

Яагаад дээрх 3 хүнийг хамгийн их итгэж болох хүн гэж бодсон, дүгнэсэн тухай шалтгаанаа бусадтайгаа заавал хуваалцаарай! Тэдэнд итгэх болсон шалтгаан чинь найзуудад чинь мөн адил итгэл хүлээлгэж болох хэн нэгнээ олоход туслах болно гэдэгт итгээрэй!

Бидний эргэн тойронд итгэж, найдаж болох маш олон хүмүүс байдаг хэдий ч хэнд нь хэрхэн итгэх, хэнээс тусламж гуйх, хэнд найдаж нууцаа дэлгэх вэ гэдгийг шийдэх хамгийн чухал. Зарим хүмүүс маш сайн сонсогч байдаг бол зарим нь маш сайн туслагч байж чаддаг. Харин зарим нь нууцыг чандлан хадгалагч байдаг.





Дасгал 3

"МИНИЙ ИТГЭДЭГ" ХҮН ЭРГЭЦҮҮЛЭЛ

/Гэрийн даалгавар/

“Миний итгэдэг хүн” сэдэвт 50 үгтэй эргэцүүлэл бичиж ирээрэй. Дараах зайг ашиглана уу!

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Одоо та бүхэн “Би хэнд итгэж болох вэ?” асуултын хариултыг олж, хамгийн их итгэж болох хүмүүсээ тодорхойлж чадсан гэдэгт эргэлзэхгүй байна.

- *Насанд хүрсэн хүн бүрт итгэх хэрэггүй гэдгийг “Н” охинд тохиолдсон явдлаас олж мэдсэн гэж бодож байна. ЖСХ-д өртсөн хүүхдүүдийн ярианаас үзэхэд тэдний дийлэнх нь буруу, итгэл хүлээлгэж болохооргүй “насанд хүрсэн” хүндээ итгэсэн байдаг. Иймд “насанд хүрсэн” хүн бүрт ямар ч шалгуургүйгээр итгэл хүлээлгэх нь буруу юм. “Яагаад би энэ хүнд итгэх ёстой вэ?” гэдэг асуултанд заавал хариулт олох хэрэгтэй.*
- *Мэдээж хэрэг эцэг, эх бол итгэл хүлээлгэж болох насанд хүрсэн хүмүүс мөн билээ. Тусламж, дэмжлэг хэрэгтэй болсон үед аав, ээжээсээ нууж хаалггүйгээр бүгдийг ярьж, ойлгуулж, ойлголцож хэвших нь чухал. Гэсэн хэдий ч дахиад л “Яагаад би аавдаа, ээждээ итгэдэг вэ?” гэсэн асуултанд хариулт олоорой.*
- *Бодит амьдрал дээр дийлэнх тохиолдолд насанд хүрсэн хүмүүс санаатайгаар болон мэдлэггүйгээсээ болоод хүчирхийлэл, тэр тусмаа жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдсэн байдаг. Танихгүй насанд хүрсэн хүнээс гадна ойр дотны хэн нэгэн, хамаатнууд ч мөн адил энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байдаг нь харамсалтай. Иймд хамаатан учраас итгэх ёстой гэж бодох хэрэггүй шүү. Зарим хамаатан ч ЖСХ үйлдэж мэднэ.*
- *Цусан төрлийн биш хэрнээ ойр дотны, итгэж болох хүмүүс бидний эргэн тойронд олон байдгийг олж харахыг хичээгээрэй. Тухайлбал, сайн найз, ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан гэх мэт хүмүүс чамд хэцүү, хүнд зүйл тохиолдоход тусалж чадна.*
- *Мэдээж хэрэг хүмүүс “хайртай” хүндээ хамгаас илүү ихээр итгэдэг. Яагаад гэвэл “хайртай” учраас. Гэтэл харамсалтай нь сайн таньж мэдээгүй, удаан үерхэж нөхөрлөөгүй “хайртай” гэж боддог хүмүүс ч хууран мэхэлж, ЖСХ үйлдсэн байдгийг санаарай.*
- *Өсвөр насны хүүхдүүдийн дийлэнх нь хамгийн сайн найзууддаа итгэж, бүх л нууцаа ярьдаг, бас тусламж эрдэг. Хэдий тийм боловч чухал шийдвэр гаргах, сонголт хийх шаардлага гарахад өсвөр насны найзуудын хамтдаа гаргасан шийдвэр тийм ч зөв байж чаддаггүй. Тиймээс л “насанд хүрсэн” хүний оролцоо, дэмжлэг, зөвлөмж чухал байдаг гэдгийг санаарай!*
- *Өндөр хөгжсөн зарим орнуудад “Нэг хүүхдийг нэг насанд хүрсэн хүнтэй хамт байлгаж болохгүй” хэмээх дүрэм үйлчилдэг байна. Өөрөөр хэлбэл хүүхдээ хэн нэгэн таних, танихгүй насанд хүрсэн хүнтэй хамт удаан хугацаанд үлдээдэггүй. Энэ нь аливаа хэлбэрийн хүчирхийллээс хүүхдээ хамгаалах нэг аргачлал болдог байна.*

Хичээлийн сэдэв:

МИНИЙ БИЕИЙН ХААНА ХҮРЧ
БОЛОХГҮЙ ВЭ?



МОДУЛЬ 7

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Чиний биеийн хаана хүрч болохгүй вэ? Чиний биед хүрч болох/ болохгүй хязгаар гэж байдаг тухай чи өмнө нь сонсож байсан уу? Эдгээр асуултуудын хариултуудыг олж мэдэхийн өмнө хичээлийнхээ зорилготой, хүрэх үр дүнтэй танилцана уу!

“Миний биеийн хаана хүрч болохгүй вэ?” сэдэвт энэ удаагийн хичээлийн гол зорилго нь ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх тухай мэдлэгээ гүнзгийрүүлж, хүчирхийллийн аливаа болзошгүй үйлдлийг урьдчилан таньж, өөрийгөө хамгаалах чадварт суралцах явдал юм.

Хичээлийг судалснаар,

- Өөрийн биеийн эмзэг хэсгүүдийг мэддэг болно.
- Биеийн эмзэг, нандин хэсгүүдэд хэн хүрч, хэн хүрч болохгүй болохыг ялгаж сурна.
- Хэн нэгэн биед нь зөвшөөрөлгүй хүрсэн тохиолдолд ямар нэгэн арга хэмжээ авах чадварт суралцана.
- Хүлээн зөвшөөрөх, үл хүлээн зөвшөөрөх харилцааны
- ЖСХ-ээс өөрийгөө хамгаалах мэдлэгтэй, чадвартай болно.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дор дурьдсан дасгалуудыг багшийн зааварчилгааны дагуу найзуудтайгаа болон бие даан хийх замаар ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах чадварт суралцах болно.

1. Энэ бол “би”
2. Зөв үү? Буруу юу?
3. Миний бие бол “Миний бие”



Дасгал 1

ЭНЭ БОЛ БИ

Доорх зайнд өөртэйгээ ижил хүйсийн хүний биеийг бүтнээр нь дүрслэн зурна уу!
Хэрэв чи эрэгтэй бол “ЭРЭГТЭЙ” хүний бие, эмэгтэй бол “ЭМЭГТЭЙ” хүний биеийг бүтнээр нь зурна гэсэн үг. Өөрийгөө зурж байна хэмээн төсөөлж болно шүү.

ЭНЭ БОЛ “БИ”

Өөрийнхөө биеийг зурж дууссан бол биеийнхээ хамгийн “ЭМЗЭГ” гэж боддог хэсгүүдэд “Х” тэмдэглэгээг УЛААН өнгөөр тавиарай! Өөрөөр хэлбэл “хэн нэгэн хүн зөвшөөрөлгүйгээр хүрч болохгүй биеийн хэсэг” гэсэн үг.

Зураг дээрээ “Х” тэмдэглэгээгээ хийж дуусаад ангийнхаа хүүхдүүдийн зураг болон тэмдэглэгээтэй харьцуулалт хийх замаар дор өгөгдсөн асуултуудын дагуу ярилцаж, түүнчлэн хариулж бичээрэй!

АСУУЛТУУД

Эмэгтэй хүний биеийн аль аль хэсгүүд хамгийн эмзэг байдаг вэ?

Эрэгтэй хүний биеийн аль аль хэсгүүд хамгийн эмзэг байдаг вэ?

Эрэгтэй, эмэгтэй хүний биеийн эмзэг хэсгүүдэд ялгаатай зүйл байна уу?

Бүх хүний биеийн эмзэг хэсгүүд нь адилхан байна уу?



Содон, нийтлэг биш биеийн эмзэг хэсэг байсан уу? Тийм бол биеийн ямар хэсэг байна вэ?

Энэхүү дасгалыг ажилласнаар өөрийн биеийн хамгийн эмзэг хэсгүүдийн талаар эргэцүүлж бодох боломжтой болохоос гадна хүйсийн ялгаатай байдлаас үүдэлтэйгээр биеийн эмзэг хэсгүүд өөр байдаг эсэх, хүн бүрийн эмзэг хэсэг адилхан эсвэл ондоо байдаг эсэхийг таньж мэдэх боломжтой болох юм.

Үүнээс гадна өөрийн биеийн аль хэсэгт хэн нэгнийг хүргэж болох/болохгүй хязгаарыг тогтоох боломжтой болно.



Дасгал 2

ЗӨВ ҮҮ? БУРУУ ЮУ?

Сургуулийн орчинд болон сурагчдын дунд өрнөдөг харилцааг илтгэсэн доорх өгүүлбэрүүдийг ээлж дараатайгаар уншиж, анхааралтай танилцана уу! Ингэхдээ тухайн өгүүлбэрт гарч буй харилцааг хүлээн зөвшөөрч байвал “ЗӨВ”, хүлээн зөвшөөрөхгүй бол “БУРУУ” гэж бичээрэй.

Д/д	ӨГҮҮЛБЭР	ЗӨВ ҮҮ?	БУРУУ ЮУ?
1.	Чамайг сургууль төгсөх шалгалтаа онц дүнтэй өгсөн гэдгийг аав чинь мэдээд чанга тэврэн хацар дээр чинь үнссэн.		
2.	С охин гудамжинд явж байгаад хагархай зам дээр хальт гишгээд хөлийн шагайгаа гэмтээжээ. Хажууд нь явж байсан залуу ирээд С охиныг суган доороос нь өргөж босгоод, бэлхүүсээр нь тэврээд гэрт нь хүргэж өгсөн.		

3.	Танай байрны нэг хөвгүүн маш хөдөлгөөнтэй / сахилгагүй/. Гадаа тоглож байхдаа байнга л байрныхаа охид, хөвгүүдийг өдөж, тоглоом шоглоом хийж явдаг. Нэг удаа байрны ах түүнийг хашраах гээд бэлэг эрхтнээс нь базсан.		
4.	Хөвгүүд охидын хөхний даруулгаас нь татаж, нурууг нь шавхуурддаг.		
5.	Хамаатны ах чинь 5 настай эмэгтэй дүүгийн чинь бөгсийг арчиж өгсөн.		
6.	Сургууль дээр зохиогдсон үдэшлэг дээр дээд ангийн аятайхан залуу чамайг бүжгэнд урьсан. Бэлхүүсний чинь доод хэсгээр тэвэрсэн.		
7.	Хичээлээ хийгээд сууж байхад багш ирээд ард зогсож, дэвтэр харангаа “сайн байна” гээд нуруу илсэн.		

Энэхүү дасгалыг ажилласнаар бусдын “санаатай” болон “санаандгүй” үйлдлийг ялгаж чаддаг болсон гэдэгт итгэлтэй байна. Заримдаа бидний урьдчилан тооцоололгүйгээр гаргасан үйлдэл хэн нэгэнд таагүй сэтгэгдэл төрүүлдэг байж болзошгүй тул өөрийн үг, үйлдэл, бусадтай харилцах харилцаа зэрэгтээ ямагт анхааралтай хандаж байх нь чухал юм. Ялангуяа бид өөрийн мэдэлгүй, мэдлэггүйгээсээ үүдэж ЖСХ үйлддэг байж ч болзошгүй.



Дасгал 3

МИНИЙ БИЕ БОЛ МИНИЙ БИЕ

/гэрийн даалгавар/

Дараах асуултуудад бие дааж хариулж бичнэ үү! Сайтар тунгаан бодох шаардлагатайг анхаараарай.



АСУУЛТУУД

Чиний биеийн эмзэг хэсгүүдэд хэн хүрч болох вэ?

Чиний биеийн эмзэг хэсгүүдэд хэн хүрч болохгүй вэ?

Чиний биеийн эмзэг хэсгүүдэд “санаатай” эсвэл “санамсаргүй” хүрсэн гэдгийг таньж мэдэх боломжтой юу?

**Хэрэв хэн нэгэн насанд хүрсэн хүн чиний биеийн эмзэг хэсгүүдэд хүрвэл чи яах вэ?
Ямар арга хэмжээ авах вэ?**

Чи өөрийгөө хэрхэн хамгаалах вэ? Өөрийгөө хамгаалж болох аргуудыг жагсааж бичээрэй!

Энэхүү дасгалыг ажилласнаар өөрийн биеэ хэнээс, хэрхэн хамгаалж болох талаар эргэцүүлж бодсон гэдэгт итгэлтэй байна. Тухайлбал, хэн чиний биеийн эмзэг хэсгүүдэд хүрч болох, харин хэн болохгүй, “санаатай” болон “санамсаргүй” хүрснийг хэрхэн таньж мэдэх гэх

зэрэг асуултуудын хариултуудыг найзтайгаа хамтран өөрөөсөө эрэлхийлж чадсан гэдэгт эргэлзэхгүй байна.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Миний биеийн хаана хүрч болохгүй вэ?” сэдэвт хичээл нь жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх өмнөх хичээлүүдийн хүрээнд олж авсан ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлэх, бусдын зүгээс биед чинь зөвшөөрөлгүй хүрэхэд ямар зорилготойгоор тухайн үйлдлийг хийж буйг ялгаж мэддэг чадвартай болоход чиглэгдсэн билээ. Өөрөөр хэлбэл хэн нэгэн чамд болон бусдад хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийж байгаа эсэхийг таних чадвартай болох нь хамгийн чухал.

- *Хүчирхийллээс ангид байх хамгийн эхний алхам нь өөрийгөө хүчирхийлэл дор байгаа эсэхийг олж харах явдал байдаг. Иймд энэ хичээл нь ЖСХ-ээс өөрийгөө болоод эрсдэлтэй бусад хэн нэгнийг (найз нөхөд, үе тэнгийнхэн, гэр бүл, хамаатан садан гэх мэт) хамгаалах чадварт суралцах мөн өөрсдөө энэ төрлийн хүчирхийллийн үйлдэгч болохоос урьдчилан сэргийлэхэд гол зорилго нь оршиж байсан.*
- *Чиний бие бол зөвхөн чиний “ӨМЧ”. Өөрөөр хэлбэл чамаас өөр хэн ч чиний биеийн талаар шийдвэр гаргах, чиний зөвшөөрөлгүйгээр биеийг чинь ашиглах ёсгүй юм. Тиймээс хэнийг биедээ хүргэх, хэнийг хүргэхгүй вэ гэдгийг зөвхөн чи өөрөө л шийдэх эрхтэй. Чамд таагүй сэтгэгдэл төрүүлж буй ямар ч харилцаа, үйлдлээс өөрийгөө хамгаалах, түүнээс зайлсхийх бүрэн эрхтэй.*
- *Бусдын биеийн эмзэг хэсэг хаана ч байж болохыг дээрх хичээлээс ойлгож авсан гэдэгт эргэлзэхгүй байна. Тиймээс бусдын биед зөвшөөрөлгүй хүрч болохгүй гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Хэрэв чи хэн нэгний биеийнх аль нэг эмзэг хэсэгт санаатай болоод зөвшөөрөлгүй хүрвэл энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэж буй явдал болохыг санаарай.*

Энэ хичээлийн үр дүнд ЖСХ-ийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, бусдын зүгээс бие махбодид нь ямар зорилготойгоор хүрч байгааг ялгаж мэдэх чадвартай болсон гэж найдаж байна. Улмаар өөрийнхөө халдашгүй байдлын үүднээс зохисгүй үйлдлийн эсрэг зоригтой эсэргүүцэж чаддаг болох нь чи ХҮЧИРХЭГ нэгэн болж байгаагийн илрэл юм.

Хичээлийн сэдэв:

БИ ХҮЧИРХИЙЛЭЛТ БУС
ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭЭЖ
ЧАДАХ УУ?



МОДУЛЬ



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСАН ЗОГСОХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Өөрчлөлт миний гарт” сэдэвт 8 модуль хичээлийн энэ жилийн сүүлийн хичээлийг судлахад бэлэн болсон та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хичээлийн зорилготой танилцаарай !

Хичээлийн зорилго нь та бүхэнд жендэрт суурилсан хүчирхийллээс татгалзах, хүчирхийлэлт бус харилцааг эрхэмлэдэг хувь хүн болж төлөвших, хүчирхийллийг өөрөө үйлдэхгүй байх, эсвэл хүчирхийлэл үйлдэж буй хүнийг зогсоох төлөвшлийг бэхжүүлэх явдал юм.

ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Хүүхдүүд ээ! Хичээлийн зааврыг багшийн хэлсний дагуу сайтар гүйцэтгээрэй. Энэхүү сэдэвт хичээл нь

1. Бүлгийн ажил
2. Хэлэлцүүлэг
3. Бие даан суралцах гэсэн дараалалтайгаар явагдана.

Дасгал 1

БҮЛГИЙН АЖИЛ

Багш та нарт дараах түүхийг ярьж өгнө. Анхааралтай сайн сонсоорой!

ТҮҮХ

Багагүй удаан хугацаанд үерхсэн хайртай охиноосоо харилцаагаа таслах болсон нь Б-д хүндхэн цохилт болов. Сэтгэл санаагаар унаж, болсон явдлын талаар хэн нэгэнтэй сэтгэлээ онгойтол ярилцмаар байсан учраас ангийнхаа найзад итгэж, найз охиноосоо яагаад салах болсон тухайгаа илэн далангүй ярьжээ. Найз охиноо үнэхээр их санаж байсан учраас түүнийхээ тухай ярьж байхдаа Б уйлчихав. Ангийн найз нь Б-ийн сэтгэлийг засч “эр хүн уйлдаггүй юм, охиноос болж уйлаад яахавдээ...” гэх мэтээр тайвшруулжээ.

Дараа өдөр нь Б-г ангидаа орж иртэл ангийнх нь бараг бүх хүүхдүүд “уйланхай, уйланхай” хэмээн хочилж, инээлдэж, шоолж гарчээ. Хүүхдүүд яагаад өөрийг нь ингэж хочлох болсныг ойлгож ядах юм Б-д байсангүй. Итгэл хүлээлгэж, сэтгэлээ хуваалцсан найз нь түүнийг “охиноос болж уйлсан” гэж ангийнхаа хүүхдүүдэд дэлгэсэн аж.

Б найздаа болон ангийнхаа хүүхдүүдэд маш их уурлажээ. Б яах ёстой вэ?

ҮҮСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛД ЯАВАЛ ДЭЭР ВЭ?

Та бүхэнд 4 өөр хувилбарыг багш танилцуулна. Эхний хувилбарыг дэмжиж байгаа сурагчид ангийн нэг буланд очиж зогсох байдлаар ангийн 4 буланд 4 багт хуваагдаж зогсоорой.

Хувилбар 1:

Б шууд л ангиас гарч явна.

Хувилбар 2:

Б-ийн уур маш их хүрсэн учраас шууд найз дээрээ очиж заамдаж авна.

Хувилбар 3:

Б уурласан хэдий ч биеэ барьж, ширээндээ сууна.

Хувилбар 4:

Б маш их уурлаж ангийнхаа хүүхдүүдэд сонсогдохуйцаар хараал хэлж, тэднийг доромжилно.

Дасгал 2

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дэмжиж байгаа хувилбарын сонголтоороо та бүхэн нэг баг болон зогссон байгаа. Багшийн асуух асуултыг сайн сонсож, тунгаан бодоод хариулахад багаараа бэлдээрэй. Мөн танай баг дунд эсвэл чамд дээрх 4 хувилбараас асуудлыг шийдэх өөр арга зам байвал түүнийгээ багшид заавал хэлээрэй. Учир нь хүн бүр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх ёстой.

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

Чиний сонгосон хувилбарын дагуу Б-д ямар байх байсан бол?

Чиний сонгосон хувилбарын дагуу бусад хүмүүс /найз, ангийн хүүхдүүд/ ямар хариу үйлдэл үзүүлэх бол?

Чиний сонгосон хувилбарын хамгийн сайн/муу тал нь юу гэж бодож байна?

Чи Б-гийн оронд байсан бол яах байсан бэ?

Хэлэлцүүлгийн дүнд чи дээрх 4 хувилбараас асуудлыг хамгийн эв найрамдалтай, хүний эрхэд суурилсан, хүчирхийлэлт бус арга нь аль болохыг тунгаан бодоорой.

Дасгал 3

БИЕ ДААН СУРАЛЦАХ

/гэрийн даалгавар/

Хүүхдүүдээ, та бүхэн ангидаа хийсэн бүлгийн ажил, хэлэлцүүлгийн үйл явцыг эргэн санаж, дараах асуултыг өөрөөсөө асууж, чин үнэнчээр хариулж бичээрэй.

Мөрөөдөлдөө хүрэх зөв гарц бол ЗӨВ ДАДАЛ, ЗАН ҮЙЛ бөгөөд тэр нь бусдыг хүндлэх, бусадтай мэндлэх зэрэг энгийн зүйлээс эхэлдэг гэдгийг ойлгоорой.

АСУУЛТУУД

Би сүүлийн 3 сарын хугацаанд хэнтэй ам муруйж, муудалцсан бэ?

Муудалцах, үл ойлголцох явдал яагаад гарах болсон бэ?

Би ямар аргаар тэр явдлыг шийдсэн бэ?

Би өөрөөр шийдэж чадах байсан уу? Эсвэл одоо болтол бидний хооронд үл ойлголцол хэвээр байгаа юу?

Надад үл ойлголцлыг арилгах хүсэл, чадвар бий юу? Хэрэв миний буруугаас болсон бол надад чин сэтгэлээсээ уучлал гуйх сэтгэлийн хүч байгаа юу?

Энэхүү дасгалыг ажилласнаар өөрийн биеэ хэнээс, хэрхэн хамгаалж болох талаар эргэцүүлж бодсон гэдэгт итгэлтэй байна. Тухайлбал, хэн чиний биеийн эмзэг хэсгүүдэд хүрч болох, харин хэн болохгүй, “санаатай” болон “санамсаргүй” хүрснийг хэрхэн таньж мэдэх гэх зэрэг асуултуудын хариултуудыг найзтайгаа хамтран өөрөөсөө эрэлхийлж чадсан гэдэгт эргэлзэхгүй байна.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Багшийн хамт өнөөдрийн хичээлээ дүгнэхээс өмнө доорх асуултуудад хариулж бичихийг хичээгээрэй.

● Б хүчирхийлэлд өртсөн үү?

● Хэрэв тийм бол ямар төрлийн хүчирхийлэл байсан бэ?

● Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл мөн уу?

● Хэрэв тийм бол яагаад?

● Хэн хүчирхийлэл үйлдсэн бэ?

● Б-ийн найз болон ангийнх нь хүүхдүүд дээрх үйлдлийг санаатай үйлдсэн үү? Өөрөөр хэлбэл санаатайгаар Б-д сэтгэл санааны дарамт учруулсан уу?

● Ийм тохиодол амьдрал дээр гардаг уу?

● Хэрэв тийм бол ихэнхдээ хэрхэн шийдэгддэг вэ?

Хэлэлцүүлгийн дүнд дараах дүгнэлтийг хийж болно.

- Хүмүүс бие биенээ санаатай болон санамсаргүй байдлаар ялгаварлан гадуурхаж, хүчирхийлдэг. Тиймээс бусдад хандах хандлага маань ялгаварлан гадуурхсан, өөрөөр хэлбэл бусдыг гомдоосон, эсвэл заналхийлсэн, дээрэлхсэн, доромжилсон байна уу гэдэгт байнга хяналттай байх нь чухал. Бусдыг шоолох, гоочлох нь ч сэтгэл санааны дарамт учруулдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.
- Зөвхөн эмэгтэйчүүд уйлж, эрэгтэйчүүд уйлдаггүй гэсэн ойлголт байдаггүй. “Жендэр”-ийн хичээлтэйгээ уялдуулж, “уйлах” гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүст адилхан явагддаг биологийн процесс гэдгийг ухамсарлах хэрэгтэй.
- Хүн бүр харилцан адилгүй тул янз бүрийн нөхцөлд янз бүрийн хариу үйлдэл үзүүлдэг болохыг ойлгох хэрэгтэй. Хэдий тийм боловч хүн бүр асуудлыг хүчээр, бусдын эрхэнд халдсан байдлаар шийдвэрлэх ёстой гэсэн үг огт биш. Хүн бүр асуудлыг шийдвэрлэх хүчирхийлэлт бус аргуудыг эзэмших шаардлагатай. Өөрөөр хэлбэл хүчирхийллийг хүчирхийллээр шийдэж, таслан зогсоож болохгүй.
- Хүчирхийллийг үйлдсэн, өртсөн нь тодорхой болсон тохиолдолд л цагдаагийн байгууллагынхан ирж арга хэмжээ авах нь зөвхөн мөсөн уулын оройд ил гарсан хэсэгт л арга хэмжээ авч байна гэсэн үг. Хүмүүс хоорондын харилцаанд гарах асуудлыг шийдэх маш олон арга байдаг бөгөөд хүчирхийлэл, хэрүүл хэл ам хийх, гар зөрүүлэх бол асуудал шийдэх ухамсартай арга биш юм.



Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 6-р хороо, Бага тойруу,
48-р байр, 305 тоот



Утас: 77119991



Цахим шуудан:

mones@mongol.net,
info@mones.org.mn,
admin@mones.org.mn



Нүүр хуудас:

Mongolian Women's Fund

